



“СОЁЛТОЙ” ЭР



Зуслангийн автобусанд багтах гэж арай л нүцгэрсэнгүй. Орсон хойноо хөлөө олохгүй баахан атигана. Уур уцаар хараал хэрүүл урд хойд хаалгаар цутгана. Суудалд шигдсэн хүмүүс хор атаа хөөрүүлнэ. Ялангуяа миний үеийн малигар цагаан залуу бүр элэг маажим тухлаад хагас бууралттай шилээ хамрынхаа үзүүрт тохон, хөлс нь цутгасан босоо хүмүүсийг тавласан янзтай булбайх нь саяхан өөхтэй маханд бялуураад, дургүй нь хүрсэн юм шиг санагдана. Гэнэт нялх хүүхэд часхийн, эргэж харвал хоёр ихэр хүүхдээ тэвэрч ядсан тамирдангуй царайтай бүсгүй үүдэнд зогсох нь түлхүүрийн нүхээр багтсан хүний үлгэрийг бодогдуулна. Би хор хөдөлгөсөн нөхрөөс (босоод адилхан над шиг зүдэрч яваг гэж санаад) “Хүүхэдтэй хүнд суудал тавьж өгье өө” гэж чангахан хэлээд харвал өнөөх гайхал сонин өмнөө бариад нугдайжээ. Гэтэл зорчигчид над уруу хялалзав. Миний танил шивнэх нь “Манай энэ чиглэлд анх удаа автобусанд сонин уншиж яваа хүнийг чи босгох гээд байхдаа яадаг юм бэ? Соёлтой хүнийг хүндлэх хэрэгтэй” гэв. Соёлт эр бүр улайрчээ. Тэр их л сонин зүйл амтархсан бололтой. . .

☆ Гэтэл ☆. Ээ, Та минь ээ! Яасан гэж санана. Өнөөх соёлт чинь юм уншаагүйгээр барахгүй, сониноор нүүрээ халхлаад гуулин чимхүүр гарган эрүүнийхээ сахлыг улангасан зулгааж харагдана. Хажууханд нэгэн эр “Манайхан сайхан болжээ. Хэзээ автобусанд ном сонин уншиж байлаа даа. Гэтэл хар. Сонин уншаад явдаг болж. . .” гэж баярлан өгүүлэхэд нь би золтой л “үхсэн хойно оо” гээд тавьчихсангүй. Удалгүй нөгөөх “соёлт” сонины нөгөө нүүрийг эргүүлээд тонгойлоо. Би ч хараа салгасангүй. . . тэр этгээд дараагийн ээлжинд шүдээ чигчийлж эхлэв.

Ээ, чааваас! Ийм л соёлт хүн бидэнтэй таарна даа. Миний зэвүү хүрч “Настай хүнд суудал тавиад өгчихвөл зүгээр л юм даа” гэж хэлээд дэргэдээ зогсож яваа өвгөнөөс дэм эрэн харахад өвгөн огт дуугарсангүй. Ямар ч гэм надад хийгээгүй мөрт нь би тэр соёлт эрийг заавал босгомоор бодогдоод болдоггүй. Өнөөх чинь дараа нь жижиг толь гарган нүүрээ хараад энд тэндээ гарсан юмаа оролдож эхлэв. Ой гутмаар гэдэг нь. Сониноо гүйцэд уншиж байгаа хүн болж байгаа юм уу хаашаа юм бэ бүү мэд. Дахиад л эцсийн нүүрийг нь эргүүллээ. Одоо л ёстой уншиж гарах байхдаа гэтэл байдаггүй ээ. Хамартайгаа ноцолдоод эхлэв. Хэлэх үг ч олдсонгүй. Нэлээд хэдэн буудал газар яваад нэг харвал мань эр сониноор нүүрээ халхлаад бөх гэгч нь унтаж харагдав.

Ж.Барамсай

1. Зохиолд хаана болж байгаа үйл явдал гарч байна вэ?

- A. Зусланд
- B. Автобусанд
- C. Номын санд
- D. Номын дэлгүүрт

2. “Ой гутмаар” гэдэг үгийн утгад тохирох хэсгийг олоорой.

- A. Жигшин зэвүүцэх байдал
- B. Сэтгэл сэргэсэн байдал
- C. Баярласан байдал
- D. Уйтгарласан байдал

3. “Соёлт эр”-ийг бусад зорчигчид яагаад хүндлэх болсныг олж тэмдэглээрэй.

- A. Автобусны сандал дээр сууж яваа болохоор
- B. Автобусанд босоо явж байгаа болохоор
- C. Сонин уншингаа сахлаа зулгааж яваа болохоор
- D. Автобусанд сонин уншиж яваа соёлтой хүн гэж бодсон болохоор

4. “Малигар цагаан залуу” гэсэн утгад үл тохирохыг нь олоорой.

- A. Тарган цагаан залуу
- B. Туранхай цагаан залуу
- C. Махлаг цагаан залуу
- D. Том цагаан залуу

5. Би баатрын хийсэн үйлдлийг дарааллаар нь зөв байрлуулсныг олоорой.

1. Автобусанд шахалдан орж ирсэн.
2. Настай хүнд суудал тавиад өгчихвөл зүгээр л юм даа гэж хэлсэн.
3. Хүүхэдтэй хүнд суудал тавьж өгье өө гэж хэлсэн.
4. Сууж байгаа малигар цагаан залууг харсан.

- A. 3,2,4,1
- B. 4,1,2,3
- C. 1,4,3,2
- D. 2,4, 1,3

6. Эхээс “**чанга ярих, бүдүүлэг**” гэсэн үгсийн эсрэг утгатай үгийг олж бичээрэй.

Миний танил нь “Манай энэ чиглэлд анх удаа автобусанд сонин уншиж яваа хүнийг чи босгох гээд байхдаа яадаг юм бэ? хүнийг хүндлэх хэрэгтэй” гэв.

7. “**Дэм эрэн харахад**” гэсэн хэсгийн доогуур зурсан үгийн ойролцоо утгатай үгийг олж бичээрэй.

.....

.....

8. “хүүхдээ” өгөгдсөн үгтэй ижил зөв бичгийн дүрэмд тохирох жишээг олоорой.

үлгэрийг
нөхрөөс
сониноо
сахлыг

9. **ТА МИНЬ ЭЭ! ЯАСАН ГЭЖ САНАНА.** гэсэн хэсэгт байгаа цэг тэмдгийг олоод, хэлэх зорилгоор ямар өгүүлбэр болохыг бичээрэй.

Анхаарлын тэмдэг
Цэг

Хүүрнэх өгүүлбэр
Анхааруулах өгүүлбэр

10. Зуслангийн автобусны зорчигчдын үйлдлээс 2-оос доошгүйг сонгоод, харьцуулан дүгнэж бичээрэй.

Би баатрын үйлдэл:

-
.....
.....
-
.....
.....

Соёлтой эрийн үйлдэл:

-
.....
.....
-
.....
.....

Дүгнэлт:

